

АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

Байршил: Налайх дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс

Эхлэх хугацаа: 2026/09/21 **Дуусах хугацаа:** 2026/10/02

Ажил эхлэх хугацаа: 2026/10 **Цалин:** Боловсрол, ажлын туршлагыг харгалзана.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2013 онд байгуулагдсан Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС) нь Монгол Улсын төрийн өмчит дээд боловсролын байгууллага юм. Тус сургууль нь Монгол Улсын болон ХБНГУ-ын Засгийн газрын дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

ЖОЛООЧ

Гүйцэтгэх үндсэн чиг үүрэг:

- Сургуулийн хүн тээврийг эрхлэх ба хариуцсан тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, цэвэрлэгээ, үйлчилгээ, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажиллах;
- Хот дотор болон хөдөө орон нутагт томилолтоор явах , гадаадын зочид төлөөлөгчдөд автобусаар үйлчлэх, байгууллагын албан хэрэгцээний шаардлагаар бичиг баримт хүргэж өгөх зэрэг ажил үүргийг гүйцэтгэх;
- Удирдлагаас өгсөн нэмэлт үүрэг даалгавруудыг гүйцэтгэх.

Тавигдах шаардлага:

- Техникийн мэргэжлийн боловсролтой байх;
- Жолооны “В”, “Д” ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрхтэй, мэргэшсэн жолоочийн үнэмлэхтэй байх;
- Мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх;
- Техникийн засвар үйлчилгээ хийх чадвартай байх;
- Хариуцлагатай, үнэнч шударга, хувийн зохион байгуулалт сайтай байх;
- Цаг баримталдаг, элдэв буруу зуршилгүй, ачаалал даах чадвартай байх.

Бүрдүүлэх материал:

- Ажилд орох өргөдөл
- Анкет
- Мэргэжлийн ур чадварыг тодорхойлсон диплом, сертификат болон батламжийн хуулбар
- Оршин суугаа хорооны тодорхойлолт
- Цагдаагийн газрын тодорхойлолт
- Өмнөх ажил олгогчийн тодорхойлох захиа

Холбоо барих:

Та баримт бичгээ монгол хэл дээр бэлтгэн 1 PDF файл болгон эмхэтгэж recruitment@gmit.edu.mn хаягаар бидэнд ирүүлнэ үү.

Цахим хуудас: www.gmit.edu.mn

Бидэнтэй +976 7023-2090 тоот утсаар болон цахим хаягаар холбогдох боломжтой.

Жич: Зөвхөн шаардлага хангасан ажил горилогчидтой эргэн холбогдож ажлын ярицлагад урих болно.